



“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр

№ 2022/01

Улаанбаатар хот

“Улаанбаатар БҮК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал 11 цаг 19 минутанд “Улаанбаатар БҮК” ХК-ийн хурлын танхимд эхлэв. Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн бүртгэл 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 11:00 цаг хүртэл явагдаж дуусав.

Хурлыг ТУЗ-ийн дарга Д.Нямхүү даргалав.

Зохион байгуулах комисс дараах бүрэлдэхүүнд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д. Байгальмаа, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал Н.Хунцэнгэл, Хүний нөөцийн менежер Г. Сувдаа нар ажилласан ба Тооллогын комисст Хууль, хангамжийн албаны дарга Д. Пүрэвцэрэн, Мэдээллийн технологийн мэргэжилтэн Л. Билүүн, Хүний нөөцийн мэргэжилтэн Н. Номин нар ажиллав.

Мөн хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулт өгөх зорилгоор ТУЗ-ийн хараат бус гишүүд: Ч. Энхбат, Г. Цогнэмэх болон Олон улсын аудитын “Grant thornton” ХХК-ийн ахлах мэргэжилтэн Батхишиг нар хуралд байлцав.

Хурлын ирц:

“Улаанбаатар БҮК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт 131 5 47 500 ширхэг саналын эрхтэй хувьцааны 128,316,000 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 97,54 хувийг төлөөлсөн 7 хувьцаа эзэмшигч оролцсон тул Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх заалтын дагуу “ирцийг хүчин төгөлдөрт тооцох” талаарх Тооллогын комиссын шийдвэрийг Комиссын дарга Д. Пүрэвцэрэн хуралд оролцогсод танилцуулав.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

1. Чапанов Мухамед /“Улаанбаатар менежмент” ХХК-ийн итгэмжлэлээр/
2. Ж. Энхтунгалаг
3. Б. Ганболд
4. М. Шигшээ
5. “Би Ди Сек” ҮЦК ХХК-ийн төлөөлөл Б.Намхайдорж /итгэмжлэлээр/
6. А. Жавхлан
7. Ж. Энхрийлэн

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж, батлах тухай;
2. Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах ;
3. “Улаанбаатар БҮК” ХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн талаар танилцуулах тухай;
4. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай;

5.ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны төсөв батлах тухай;

Хурлын дарга Д.Нямхүү ээлжит хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулсныг Хувьцаа эзэмшигчид батлав.

Хэлэлцэх асуудал-1:

“Улаанбаатар БҮК” ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж, батлах тухай;

“Улаанбаатар БҮК” ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Гүйцэтгэх захирал Х. Золжаргал танилцуулав.

ТУЗ-ийн дарга Д. Нямхүү: “Манай компани 2021 онд бүтээн байгуулалтанд оролцоогоо нэмэгдүүлнэ” гэсэн зорилго дэвшүүлж ажилласан. Зарим гол ажлаас дурьдвал:

- “Оюу толгой” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж далд уурхайн замын хажуугийн хавтан үйлдвэрлэн нийлүүлсэн.
- “УБТЗ”-д 25,000 бетон дэр нийлүүлсэн.
- “МТЗ”-д 480,000 бетон дэр нийлүүлсэн.

Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ тоног төхөөрөмж ашиглаж эхэлсэн: бутлан ангилах үйлдвэрийн хүчин чадлыг 33%-р нэмэгдүүлж, элс хайргаа ангилж хадгалах зориулалтын бетон хашлагууд хийснээр элсний тоосны агууламжийг хамгийн бага хэмжээнд буулгаж чадсан. Түүнчлэн элс хайргын бункерийг халаах төхөөрөмжийг бүрэн шинэчилсэн. Эдгээрээс гадна аюулгүй ажиллагааг хангах, түүхий эд татан авах вагоны замын шинэчлэлт, орчны бохирдлын шийдэл зэрэг чиглэлээр томоохон өөрчлөлтүүдийг хийж ажилласан. Бид цаашид бүтээн байгуулалт, өөрчлөлт шинэчлэлийг тогтмол хийснээр 2 жилийн хугацаанд Европын стандартад нийцсэн үйлдвэр болохоор зорьж ажиллаж байгаа хэмээн тэмдэглэв.

Хуралд оролцогчид тайлантай холбогдуулан зарим асуудлуудыг тодруулж холбогдох хариултыг авсан ба компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх “Улаанбаатар БҮК” ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг “хангалттай” гэж ТУЗ дүгнэснийг батлах талаар санал хураалт явуулав.

Санал хураалтын дүнг Тооллогын комиссын дарга Д. Пүрэвцэрэн танилцуулав.

Санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 0

Санал хураалтын дүн: 100%

ШИЙДВЭР:

“Улаанбаатар БҮК” ХК-ийн 2021 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг “хангалттай” гэж батлах.

Хэлэлцэх асуудал-2:

Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай;

Компанийн ТУЗ-өөс 2022 онд нэгж хувьцааны ногдол ашгийг 10 төгрөгөөр тооцож нийт 1,315,475,000 төгрөгийн ногдол ашгийг 6 дугаар сарын 1-ний дотор ҮЦТХТ-өөр дамжуулан тараах шийдвэр гаргасныг Хурлын дарга Нямхүү уншиж танилцуулав.

Хэлэлцэх асуудал-3:

“Улаанбаатар БҮК”ХК-ийн 2022 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн талаар танилцуулах тухай;

Гүйцэтгэх захирал Х. Золжаргал “Улаанбаатар БҮК”ХК-ийн 2022 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн талаар 2021 оны эдийн засгийн хүрсэн түвшинтэй харьцуулан дараах байдлаар танилцуулав.

Стратегийн чиглэл зорилго	Үзүүлэлт ¹	2021: Суурь түвшин	2022: Зорилтот түвшин	2024: Зорилтот түвшин
Бүтээн байгуулалтад оролцоогоо нэмэгдүүлж бизнесийн өсөлт, ашигт ажиллагааг сайжруулан тогтворжуулна	Борлуулалтын орлого, тэрбум	39.167	61,705	85,000
	Нийт ашгийн марж	40%	41%	43%
	Нэгж хувьцаанд ногдох ЦА	23	68	125
	Хөрөнгийн өгөөж (ROA)	5%	13%	20%
Хэрэглэгчид хүргэх үнэ цэнэ рүү төвлөрч, зах зээлийн тэргүүлэгч байр сууриа бэхжүүлнэ	ТБХЭ-н зах зээлд эзлэх %	16.6%	20%	25%
	Шинэ бүтээгдэхүүн технологи	4	4	6
	Хугацаандаа биелэсэн гэрээ/захиалга, %	81%	90%	99%
	Дэмжигч хэрэглэгчдийн хувь (NPS)	25.5%	28.5%	30%
	Хэрэглэгчийн сэтгэл ханамж	79%	85%	95%
	Чанартай гарц / Нийт гарц	99.5%	99.7%	99.8%
Бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, бүтээмжийг сайжруулж аюулгүй ажиллагааг хэвшүүлнэ	Орлого/Хүний тоо, сая төг	147	172	212
	ISO стандартууд нэвтрүүлэх төлөвлөгөөний биелэлт	5%	100%	-
	Гэмтлээс үүдсэн өвчлөл (LTC)	0.37	0.0	0.0
	Ажилтны сэтгэл ханамж (> 80% ханамжтай/Нийт)	-	80%	88%
Бизнес удирдлага, дэд бүтэц, техник технологи, систем болон хүний нөөц зэрэг байгууллагын чадавхийг тогтмол хөгжүүлэн шинэчлэн сайжруулна	ХН тогтворжилт	66%	75%	85%
	Сургалтын төл. биелэлт	100%	100%	100%
	БМатериал хяналтын систем	10%	80%	100%
	Бизнес төлөвлөгөө биелэлт	69%	75%	88%

Хэлэлцэх асуудал- 4:

ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай:

ТУЗ-ийн дарга Д. Нямхүү ТУЗ-д 9 хүнийг нэр дэвшүүлэхээр Нэр дэвшүүлэх хорооноос гаргасан шийдвэрийг, тэдгээр гишүүдийн танилцуулгын хамт танилцуулав.

ТУЗ-д нэр дэвшүүлсэн гишүүдэд куммулятив аргаар санал хураасан дүнг Тооллогын комиссын дарга Д. Пүрэвцэрэн танилцуулав.

Санал хураалтын дүн:

1.1. Ердийн гишүүд

- 1.Д. Нямхүү-д өгсөн санал: 128,316,000
- 2.Д. Мөнхөө-д өгсөн санал: 128,316,000
- 3.Х.Ю.Хамхоев-д өгсөн санал: 128,316,000
- 4.М.А.Чапанов-д өгсөн санал : 128,316,000
- 5.Х. Золжаргал-д өгсөн санал: 128,316,000
- 6.О. Басанхүү-д өгсөн санал : 128,316,000

1.2. Хараат бус гишүүд

1. С.Б.Громов-д өгсөн санал: 128,316,000
2. Г. Цогнэмэх-д өгсөн санал: 128,316,000
3. Ч. Энхбат-д өгсөн санал: 128,316,000

ШИЙДВЭР:

ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдээр дараах гишүүдийг сонгохоор шийдвэрлэв.

Үүнд:

1.1. Ердийн гишүүд

- 1.Д. Нямхүү
- 2.Д. Мөнхөө
- 3.Х.Ю.Хамхоев
- 4.М.А.Чапанов
- 5.Х. Золжаргал
- 6.О. Басанхүү

1.2. Хараат бус гишүүд

1. С.Б.Громов
2. Г. Цогнэмэх
3. Ч. Энхбат

Хэлэлцэх асуудал- 5:

ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны төсөв батлах тухай;

ТУЗ-ийн 2022 оны төсвийн талаар Хурлын дарга Д. Нямхүү танилцуулсан ба ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлсийг тэдний идэвх зүтгэл, хувь нэмэр, инфляцийн өөрчлөлт, гадаад валютын ханшийн өсөлт зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан нэмэх санал оруулсныг хурьцаа азмигчид дэмжив.

Санал хураалтын дүнг Тооллогын комиссын дарга Д. Пүрэвцэрэн танилцуулав.

Санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн:7

Татгалзсан: 0

Санал хураалтын дүн: 100%

ШИЙДВЭР:

ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны төсвийг 217,605,200 төгрөгөөр баталж 2022-4-01-ний өдрөөс дараагийн ээлжит Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл мөрдөж ажиллахыг хуралд оролцогсад дэмжив.

Хурал даргалагч Нямхүү: Өөр хэлэлцэх асуудал байхгүй тул “Улаанбаатар БҮК” ХК-ийн ээлжит хурал хаасныг мэдэгдэв.

Хурал 14 цаг 25 минутанд дуусав.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Зохион байгуулах комиссын гишүүн



Г. Сувдаа